



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР



# Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ

2024 оны 10 дугаар сарын байдлаар

Мөрөн сум



# 1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

## 1.1. Төрөлт

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар 1601 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 255 тохиолдол буюу 13,7%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Цэцэрлэг сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Төрсөн эхчүүдийн 1201 нь буюу 75,0 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа бөгөөд Бүрэнтогтох, Цэцэрлэг, Мөрөн суманд бүртгэгдсэн байна.

2024 оны эхний 10 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 25.2 хувийг эзэлж, нийт төрөлтөөс 25,6 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 74,4 хувь нь хүндрэлгүй төрсөн байна. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 11.7 байна.



## 1.2 Хүүхдийн эрүүл мэнд

2024 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд 1604 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 261 хүүхдээр буюу 14.0 хувиар буурчээ.

Амьд төрсөн хүүхдийн 819 буюу 51.1 хувь нь хүү, 785 буюу 48.9 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 104 хүү ногдож байна.

Амьд төрсөн нийт хүүхдээс 66 нярай буюу 4.1 хувь нь 2500 грамаас доош жинтэй, 15 тохиолдол буюу 0.9 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 97.8 байна. Дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 59.3 байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 6.2 байна.

2024 оны эхний 10 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 47975 хүүхэд хамрагдсанаас 0.02 хувь нь туранхай, 0.1 хувь нь тураалтай, 0.1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 56.9 хувь нь Д амин дэм, 7.5 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 13757 хүүхэд хэрэглэсэн байна.

## 1.3. Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Сүүлийн 5 жилийн дундажаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 40.3 байна.


## 1.4. Нялхсын эндэгдэл


Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 26 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.2 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 65,4 хувь нь эрэгтэй, 34,6 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийн 69.2 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 11.2 байна. Нярайн эндэгдлийн нийт 18 тохиолдлын 12 буюу 66.7 хувь нь эрт үеийн эндэгдэл, 6 буюу 33.3 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна.

2024 оны эхний 10 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг сумуудаар харьцуулбал: Арбулаг (250.0), Бүрэнтогтох (250,0), Галт (272.7), Ханх (90.9) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 46.2 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 23.1 хувь, гадны шалтгаант осол гэмтэл 15.4 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 15.4 хувийг тус тус эзэлж байна.





### **1.5. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл**

2024 оны эхний 10 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор буурсан, 1000 амьд төрөлтөнд 4,4 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл амьсгалын тогтолцооны эмгэг 3, мэдрэлийн тогтолцооны эмгэг 1, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.



### **1.6. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 33 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 20,6 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор өссөн байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 22 тохиолдол 66,7 хувь нь эрэгтэй, 10 тохиолдол буюу 33,3 хувь нь эмэгтэй хүүхэд байна.



Нийт тохиолдлын 30,3 хувь нь гэртээ болон гудамж талбайд, 69,7 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 48,5 хувийг эзэлж байна. Шалтгаанаар авч үзвэл: Нийт эндэгдлийн 73.1 хувь нь өвчнөөр, 26.9 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 36.4 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 21.2 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 21.2 хувь, гадны шалтгаант осол гэмтэл 21.2 хувийг тус тус эзэлж байна.

Сумуудаар харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Арбулаг (250.0), Бүрэнтогтох (500,0), Галт (272.7), Жаргалант (333.3), Тариалан (58.8), Ханх (90.9), Хатгал (58.8) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.



## **2. ХҮН АМЫН НАС БАРАЛТ**


2024 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 643 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 40 тохиолдлоор өссөн байна.

Нийт нас баралтын 416 тохиолдол буюу 64,7 хувь нь эрэгтэй, 227 буюу 35,3 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 18,5 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 45 тохиолдол буюу 37,8 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор өссөн байна.


Нас баралтын түвшин 1000 хүн амд 4,7 байна. Нас баралтын 4,0 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5.1 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 18.8
2. Хавдар-13.2
3. Гадны шалтгаант өвчлөл- 7.9
4. Амьсгалын тогтолцооны өвчин-1.7
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-1.4



Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 108 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 16,8 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 38 тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 7.9 байна.




#### 4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ

2024 оны эхний 10 сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт нас баралтын 84 тохиолдол бүртгэгдсэнээс 42.9 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд үндсэн оношийн зөрүү 5 тохиолдол бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 48 тохиолдол байна.

#### 5. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

##### 5.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ


Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 610645 эмчийн үзлэг хийгдсэнээс 45.3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 39.1 хувийг өвчний учир амбулаторт, 6.1 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 9.6 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 2228.6 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэг 103632 буюу 37.5 хувиар өссөн байна.



## **5.2 Жирэмсний хяналт**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 1436 эмэгтэйчүүд хамрагдсан ба 91,2 хувь нь эхний 3 сартайд, 8.1 хувь нь 4-6 сартайд, 0.8 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 93,1 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 1,4 хувь нь цус багадалттай байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз болон заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.3 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 95,7 хувь, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 95,5 хувь нь хамрагдсан байна.



## **5.3 Үр хөндөлт**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 20 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн ба нийт үр хөндөлтийн 20 тохиолдол буюу 50.0 хувийг хожуу үр хөндөлт, 10 тохиолдол буюу 35.0 хувийг өсвөр насны үр хөндөлт эзэлж байна.

## **5.4 Халдварт бус өвчлөл**

2024 оны эхний 10 сарын байдлаар халдварт бус өвчлөл 84748 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 35654 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 6166.8 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1151 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.4 хувийг эзэлж, 10000 хүн амд 84.1 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/


1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1663.5
2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 1139.0
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-947.9
4. Нүд ба түүний дайврын өвчин-520.5
5. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-514.3




## 5.5 Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 45967 (52.8%) хүн хамрагдсан бөгөөд 43,3 хувь нь эрэгтэй, 56.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 19.0 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна.


Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 33990 (63.2%) хүн хамрагдсанаас 42,0 хувь нь эрэгтэй, 58,0 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 11.9 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна.




Элэгний эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр





16-65 насны БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



## **5.6 Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 5544 (59,1%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 0,2 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй гарсан байна.

Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 29437 (69,0) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт (1.0%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.



## **5.7 Түргэн тусламжийн дуудлага**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар 16657 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 14,3 хувь /2380/ нь алсын дуудлага, 2.5 хувь /417/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 50,5 дуудлага, АНЭ 14,8 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

## **5.8 Хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээ**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар 24870 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 165828 ор хоног ашигласан байна. Аймгийн дунджаар ор ашиглалтын хувь 68,5 дундаж ор хоног 6.7 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 172 хүнээр, ор хоног 737 тохиолдлоор тус тус өссөн байна.

## **6. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Өрхийн ЭМТ нийт үзлэг 167416 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 62.2 хувь
- Өвчний учир үзлэг 12.0 хувь
- Диспансерийн хяналт 6.9 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 18.5 хувь
- Гэрийн дуудлага 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 3845 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 9.1 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 506 жирэмсэн эмэгтэйгээс 87.7 хувийг эрт үед нь хяналтанд авч 94.3 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 211 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 41 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 63, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 6 тохиолдол эндсэн байна.

## **7. ХУВИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Хувийн эмнэлгүүд нийт 31945 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 11.7 хувь
- Диспансерийн хяналт 2.8 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 0.01 хувь
- Гэрийн дуудлагаар 0.01 хувь
- Өвчний учир үзлэг 85.4 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 7055 хүн хэвтэн эмчлэгдэж, 50441 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.1 орны эргэлт 21.4 ба орны фонд ашиглалт 152.9, орны фонд ашиглалтын хувь 55.6 байна.

Нийт халдварт бус өвчний 2408 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 598 тохиолдол бүртгэгдсэн байна.

## **8. ХАЛДВАРТ ӨВЧИН**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар 13 төрлийн 1080 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 78.6 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 49 тохиолдлоор буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 3.8-өөр өссөн байна.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнийг сумуудаар харьцуулбал: Баянзүрх (78,9), Тосонцэнгэл (99,2), Цэцэрлэг (93,7), Чандмань-Өндөр (91,8), Мөрөн (131,1) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.


### **8.1. Халдварт өвчний нас баралт**

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний нас баралтын 3 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор өссөн байна. 10 000 хүн амд 0,2 байна. Нийт халдварт өвчний нас баралтын 2 тохиолдол нь сүрьеэгийн нас баралт, 1 тохиолдол нь цусан суулгын өвчний шалтгаант нас баралт байна.

### **8.2. Цочмог халдварт өвчин**

Нийт цочмог халдварт өвчний 582 тохиолдлоос:

- Хоолны хордлого 9 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 47 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастрозентерит ба суулга 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хепатит В 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хепатит С 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Сүрьеэ 37 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 24 тохиолдлоор
- Ёлом 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор
- Хачигт энцефалит 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор
- Ковид-19 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 46 тохиолдлоор тус тус буурч
- Цусан суулга 85 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 30 тохиолдлоор
- Салхинцэцэг 412 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 280 тохиолдлоор
- Гахайн хавдар 4 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор тус тус өсч
- Сальмонеллэз 1 тохиолдол, гар хөл амны өвчин 22, Хачигт рикеттиоз 7 тохиолдол тус тус өмнөх оны мөн үетэй адил тохиолдол байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.



### 8.3. Амьсгалын замын халдварт өвчин



2024 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 449 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 44,4 хувийг эзэлж байна. Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 229 тохиолдлоор өссөн байна.

### 8.4. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин

2024 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 498 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 46,1 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 128 тохиолдлоор буурсан байна.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 25.1 хувийг тэмбүү, 64.9 хувийг заг хүйтэн, 10.0 хувийг трихомониаз тус тус эзэлж байна.

- Тэмбүү 125 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор
- Трихомониаз 50 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор тус тус өсч
- Гонококкт халдвар 323 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 154 тохиолдлоор буурсан байна.






## 9.ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ


2024 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 574 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 70.2 хувь (403), цочмог халууралт тууралтат 9.9 хувь (57), цочмог цусархаг тууралтат 17.1 хувь (98), цочмог усархаг 0.7 хувь (4), цочмог шарлалттай 0.5 хувь (3), гахай хавдар 0.5 хувь (3), хоолны хордлогот халдвар 0.9 хувь (5), боом 0,2 (1) тус тус бүртгэгдсэн байна.

Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/



Тохиолдлын нэр	2023 он		2024 он	
	бодит тоо	дүнд эзлэх хувь	бодит тоо	дүнд эзлэх хувь
Халууралт тууралт	64	19.5	57	9.9
Цэврүүт тууралт	149	45.4	403	70.2
Цусархаг суулгалт	46	14.0	98	17.1
Усархаг суулгалт	6	1.8	4	0.7
Цочмог шарлалт	7	2.1	3	0.5
Гахайн хавдар	0	0.0	3	0.5
Боом	0	0.0	1	0.2
Хоолны хордлогот халдвар	56	17.1	5	0.9
<b>Нийт</b>	<b>328</b>	<b>100.0</b>	<b>574</b>	<b>100.0</b>


### Халдварт өвчний хамшинж, сэжигтэй нийт тохиолдол, бүртгэгдсэн долоо хоногоор





### 9.ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2024 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 29550 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 2144.4 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 23088 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1687.2 болсон байна.

#### Томуу, томуу төст өвчин, 10 000 хүн амд







ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

М.ҮҮРИЙНБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА